



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

«Олон улсын «PISA-2022» үнэлгээний Монгол  
Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн хүрээнд  
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 35.6, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.1, 10.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын «PISA-2022» үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай:

1.1.үнэлгээний үр дүнд үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газраар батлуулж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх;


1.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эх хэл болон унших суурь чадварыг сайжруулахад чиглэсэн зорилтот арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;

1.3.үнэлгээний үр дүнд үндэслэн хот, орон нутгийн боловсролын чанарын ялгааг арилгах чиглэлээр ерөнхий боловсролын сургуульд байгалийн ухаан, математик, англи хэлний цахим сургалт, цахим сурах бичиг, контентын санг нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

1.4.олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагатай хамтран боловсролын цахим үнэлгээг нэвтрүүлэх;

1.5.2025 онд сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA үнэлгээнд дахин хамрагдах бэлтгэл хангах.

2.Энэ тогтоолын 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН